

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№ 07/280

НШУС

2007

СЭТГҮҮЛЗҮЙН ДӨРВӨН ОНОЛ ДАХЬ ХҮНИЙ ТУХАЙ АСУУДАЛ

Б.Болд-Эрдэнэ*

* МУИС, НШУС, Сэтгүүл зүйн тэнхмийн багш, доктор (Ph.D.), МУИС-ийн дэд профессор

Түлхүүр үг: сэтгүүл зүйн онолууд, авторитар онол, либертари онол, нийгмийн өмнө хариуцлагатай онол, зөвлөлтийн коммунист онол, хүний тухай асуудал.

Сэтгүүлзүй нь мөн чанараараа бол хүний тухай хүнд хүргэдэг тэгэхдээ нийгмийн үнэлэмж, хандлага, эрх ашгийн зөвшил болоод зөрчлийн "агуу том" орон зайд оршдог харилцаа юм. Тиймээс бид асуудлыг хүний ертөнцөөс ангид улс төр эдийн засгийн тогтолцоо, үйл явц, үзэгдэл, асуудлын талаас илүү ойлгож дүгнэсээр иржээ. Гэтэл сэтгүүлзүйн үр нөлөө, зорилгын "эцсийн зогсоол" болох хүнд юу өгөв, яагаад цаг үеийн энэ их мэдээллийн урсгал хүнд хэрэгтэй юм бэ, эцсийн эцэст хүн гэгч хэн бэ түүнийг хэвлэл мэдээллийнхэн хэрхэн яаж ойлгож байгаа нь бага яригдаж байгаа нь нууц биш. Тиймээс хүний тухай асуудлыг

сэтгүүлзүйн онол үзлийн "цонхоор" тоймлов. Энэ ч үүднээс нилээд түгээмэл хэлэлцдэг, харьцангуй бүрэн дүүрэн, хүлээн зөвшөөрөгдсөн сэтгүүлзүйн онолын томъёолол болох авторитар, либертари, нийгмийн өмнө хариуцлагатай зөвлөлтийн коммунист гэсэн хэвлэлийн дөрвөн онолыг үндэслэн тодорхойллоо.

Авторитари онолын философи үндэс нь хүн ба төр хоорондын харьцаа үнэлэмжид байгаа юм. Үүнд юуны өмнө хүн бол зөвхөн нийгмийн дэмжлэг оролцоотойгоор сая өөрийн хүсэл зорилгыг бодит зүйл болгоно гэсэн үзэл баримтлалын гаргалгаанаас эхэлдэг. Мэдээж энэ нь хувь хүний үйл амьдрал зорилго, үзэл бодол гэгч хязгаарлагдмал, харин нийгмийн дунд, тэдний нэг байвал хүн боломж нь нэмэгдэнэ гэсэн үг. Ийм тохиолдолд хамт нийтийн үүрэг нөлөө хувь хүнийхээс илүүд тавигдаж, хэн ч тэр бусдынхаа дэмжлэг, хүслээр л зорилгодоо хүрэх болно. Ийнхүү автори-

тар онолын "төр бол хамт нийтийн эрхэмлэлт үнэлэмж, эрх ашгийг хувь хүнээс илүү илэрхийлэгч, төр үгүйгээр хувь хүн өөрийн хүсэл зорилгодоо хүрч чадахгүй" гэсэн 'эргэцүүлэлд хүргэж байгаа юм. Энд хүн төрөөс хараат байхын шалтгааныг "иргэншсэн нийгэмд хөгжих" бололцоо нөхцөл байдлыг хангагч гээд үүнийгээ ч төрийн нэгэн үүрэг гэж үздэг. Өөрөөр хэлбэл хүний хүсэл зорилго төрд оршиж, төрөөр илэрхийлэгдэх ёстой ба үүнээс өөр байх ахул бүдүүлэг, байж боломгүй зүйл болно гэсэн үг. Тэгэхлээр төр бол хүний хөгжлийн бодит хүчин зүйл болж таарч байна. Энэ бол төрийн тогтолцооны оршин байх суурь, амин чухал үзэл, тайлбар бөгөөд түүнд ч нийгмийн, хамт нийтийн бүхий л сайн сайхан бүрэлдэн төлөвшиж бас илэрхийлэгдэх ёстой болно. Энэ нь бурхны таалал, цэцэд мэргэдийн агуу ухаан, эсвэл лидерийн түүхийн өмнө хүлээсэн үүрэг магадгүй ард түмэн үндэстний хувь тавилан зэргээр нотлогдон, баталгаажиж байх жишээтэй.

Нөгөө талаар авторитар онолд мэдлэг болоод үнэний тухай асуудал онцгой байр эзэлдэг нь санаандгүй хэрэг биш ээ. Мэдлэг бол оюун ухааны хүчин чармайлтын үр дүн байдаг гэнэ. Гэтэл хүний ухамсар, оюун ухаан чадавхи өөр өөр, ялгаатай байдгаас мэдлэгийн

төвшин адил байх боломжгүй нь тодорхой юм. Ингээд энэхүү ялгааг нийгмийн хүрээнд нэгтгэн зохицуулах шаардлага урган гарч, цэцэд мэргэдийн, эсвэл тийм зөвлөгчдийн "орон зай" нийгэмд бий болж тэд удирдагч, эрх баригчид байх ёстой болно. Тэгэхлээр бурхны тааллаас бусад нь хүний хүчин чармайлтаар нийгмийн баялаг, үнэт чанар болон орших ба үүнийг бий болгох, хамгаалахад төрийн үүрэг онцгой чухал гэдэг нь ойлгомжтой ажгуу. Ингээд төрийн "хүсэл зорилго" хувь хүнийх болж, нийгмийн хэм хэмжээ, зан төлөв бүхнийг зохицуулснаар аливаа шүүмжлэл, үгүйсгэл зөрчил нь буруу, самуун зүйл мэт үнэлэгдэж, харин тогтвортой байдал, уламжлал нь сайн, зөв зүйтэй, "гэгээн" хандлага болон ойлгогдоно. Тэгээд ч оюун ухаан, мэдлэг нь нэгдмэл байх цорын ганц орчин нөхцөл нь төрийн тогтолцоонд орших болой.

Либертари онолын эх үндэс нь арван долдугаар зууны үеэс тавигдсан ба ардчилсан нийгэм, улс төрийн тогтолцооны үзэл санааны салшгүй нэгэн хэсэг болон хөгжсөөр иржээ. Энэ нь хэвлэл мэдээлэл, үзэл бодлын эрх чөлөө нь хүний төрөлх эрх бөгөөд нийгмийн амьдрал, хөгжлийн зорилго нь хүний хөгжил байх төдийгүй, хүн өөрөө өөрийгөө мэдэх чадвар чадавхитай бие даасан "ертөнц" гэсэн

тайлбар дүгнэлтийн хүрээнд үндэслэл шалтгаанаа томъёолдог. Өөрөөр хэлбэл нийгэм нь хүнээс эхэлж, хүнээр төгсдөгийн адил аливаа зөрчил хямрал, хөгжил дэвшил нь хүнтэй холбогдож, хүн л тэр бүхнийг шийдэж, эсвэл дэмжин тэтгэгч хүч нь болдог гэсэн үг. Хүний адгуус амьтдаас ялгагдах "сэтгэж буйгаа ухамсарлах" чадвар чадавхи нь ч эрх чөлөөтэй, өөрийнхөөрөө байх чанарыг тодорхойлж байгаа юм. Тэгээд ч хувь хүн эрх ашиг, сонирхол үзэл санаагаа нээлттэй, чөлөөтэй илэрхийлэх нь өөрөө нийгмийн хүсэл зорилго мөн чанар нь байх ёстой гэдэг. Харин төр бол хувь хүний амьдрах, хүссэнээ хийх, бодол санаагаа илэрхийлэх, өөрийнхөөрөө байх тэрхүү орчин нөхцөл боломжийг хангагч, түүнд үйлчлэгч нийгмийн "хэрэгсэл, арга хэлбэр" болдог. Хүний үзэл бодлын эрх чөлөө, эрхэмлэл нь төрөлх чанартай бөгөөд үүнийг бурхан ч бай, байгаль ертөнц ч бай, эсвэл хүн өөрөө олсон ч бай түүнийгээ бүрэн дүүрэн "ашиглаж, хэрэглэж" байж сая жинхэнэ утгаараа "хүн" байх болно. Үнэн гэдэг бол урьд өмнө тогтоогдсон, эсхүл

хэн нэгнээс "суралцдаг" зүйл биш бөгөөд хүн өөрөө ухаарч ойлгож нээж байдаг, янз бүрийн бодол санаа, үзэл хандлагын маргаан мэтгэлцээн, өрсөлдөөн дунд "гэрэлтэгч" тийм ойлголт хэмээн либертари онол тайлбарладаг. 1688 оны Английн "зөөлөн" хувьсгалаар парламент хаант засаглалын титмийн дээр гарч, 1689 онд "Эрхийн тунхаг"-ийг хүлээн зөвшөөрүүлэн, хүний "эртний, үнэн, эргэлзэшгүй эрхийг" дээдлэх эзэн хааны хүндэтгэлийг зарласнаар либертари онол эргэлтгүй хүн төрөлхтний "үзэл санаа" болсон юм. Гэхдээ энэхүү агуу үйл явдлын "ухаан сэтгэлийг" бүтээгч нь яах аргагүй Жон Локк

«

1688 оны Английн "зөөлөн" хувьсгалаар парламент хаант засаглалын титмийн дээр гарч, 1689 онд "Эрхийн тунхаг"-ийг хүлээн зөвшөөрүүлэн, хүний "эртний, үнэн, эргэлзэшгүй эрхийг" дээдлэх эзэн хааны хүндэтгэлийг зарласнаар либертари онол эргэлтгүй хүн төрөлхтний "үзэл санаа" болсон юм.

»

байж эрх мэдлийг хязгаарлах, хуулийн үндсэн дээр ард нийтийн эрх, хүсэл зоригийг хамгаалах, янз бүрийн шашны номлол суртлыг хүлцэн тэвчих, хувь хүний эдийн засгийн эрх чөлөөг хангах тухай үзэл онолыг үндэслэсэн юм. Тэрээр хүн өөрийн эрх мэдлээ төр засагт түүний төрөлх, зайлшгүй эрхийг хамгаалах болзолтойгоор шилжүүлсэн болохыг зарлаж, "Хүний эрх төр үүсэхээс өмнө байсан тул түүнийг байгалиас

заяасан эрх гэдэг. Байгаль бидэнд эрхийг өгчээ. Хүн эдгээр эрхээ хамгаалахын тулд төрийг бий болгодог. Хэрэв төр энэ үүргээ хэтрүүлбэл хүмүүс түүний эсрэг босох эрхтэй”¹ хэмээн тодотгожээ. Ийнхүү либертари философи хэвлэл мэдээллийн нийгмийн үүрэг, байр суурийг авторитари хандлагын эсрэг томъёолсон юм. Тодруулбал, хувь хүний хүчин зүйлийг онцолж, түүний тунгаан бодож шүүмжлэх чадвар чадавхи түүнчлэн төрөлх эрхийн ойлголтын салшгүй хэсэг болсон үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөө нь нийгмийн дэг журамд зонхилгоч нөлөө, байр суурьтай болох тухай онол үзлийг бий болгожээ.

Энэ тухай профессор К.Беккер “...үнэнийг мэдэхийг хүсч түүнийг эрмэлзэх нь хүний мөн чанар билээ. Нөгөөтэйгүүр үнэнд хүрэх цорын ганц зам нь чөлөөт орчин нөхцөлд үзэл бодлоороо өрсөлдөх явдал юм. Үүнийг цааш нь лавшруулан эргэцүүлбэл хүмүүсийн үзэл бодол өөр өөр, янз бүр байх тул хүн бүр өөрийн байр суурь, санаа бодлоо чөлөөтэй тэр бүү хэл идэвхитэйгээр хамгаалах эрхтэй ба гэхдээ энэ нь тэр бас бусдын тийм эрхийг зөвшөөрсөн үед л сая бодит зүйл болох нь ойлгомжтой. Эцэст тэмдэглэхэд энэхүү бүх нийтийн хүлцэн тэвчихүйн соёл нь янз бүрийн үзэл бодлын өөр хоорондын нэвчилтийг идэвхижүүлж,

улмаар бүгдийн хүлээн зөвшөөрсөн хамгийн ухаалаг шийдвэрт хүрдэг”² гэжээ.

Либерал үзлийн “эцэг” Жон Милл хүний ямар ч үйл, хандлага илүү олон хүнийг илүү аз жаргалтай байхад оршиж, зорилго чиглэл нь болсноор, харин нийгэм нь илүү олон хүнийг илүү аз жаргалтай байх орчин нөхцлийг бүрдүүлснээр зүй зохист болно гэсэн утилитар үзэл санааг дэвшүүлж байснаараа онцгой юм. Тиймээс ч нийгэм сайн сайхан бүхний эх өлгий байхын нэгэн зам, нөхцөл нь түүний төлөөлөл гишүүн бүр бодож сэтгэж, өөрийнхөөрөө байж, хүссэнээ хийх боломж, эрхийг эдлэх ёстой гэж үзжээ. Тэгээд ч үзэл бодлын эрх чөлөө, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөгөөр илэрнэ гэсэн байх юм. Үүнийгээ ч дөрвөн эргэцүүлэл дүгнэлтээр тодотгожээ. Энэ нь “нэгдүгээрт, хэрвээ бид үзэл бодлоо илэрхийлэх боломжийг үгүйсгэвэл үнэнийг мэдэж чадахгүй болно. Хоёрдугаарт, буруу, алдаатай үзэл бодолд ч бүрэн дүүрэн үнэнийг нотлоход зайлшгүй хэрэгтэй өчүүхэн ч гэсэн хэсэг байж болно. Гуравдугаарт, бүх нийтийн хүлээн зөвшөөрсөн үнэнийг ч тэр хэрвээ хамгаалан бататгахгүй юм бол нэг л өдөр зүй зохист гэхээсээ илүү балай дэмийрэл хэмээн нийгмээрээ хэлэлцэх болой. Дөрөвдүгээрт, хэрвээ нийтээр хүлээн зөвшөөрсөн үзэл бодлыг үе үе шүүн тунгаан хэлэлцэхгүй бол түүний хэрэг

ашиг тус гэж байхгүй болж мартагдана”³ гэсэн эргэцүүллүүд юм.

Нийгмийн өмнө хариуцлагатай сэтгүүлзүй хэмээх нэр томъёо ХХ зууны эхээр, цэвэр “либерал” үзэл баримтлалын зарим нэг тодорхойгүй, эргэлзээтэй асуудлыг нягтлах, мэдээллийн бодит үнэн байдлыг хангах, дуулиан шуугианаас татгалзан “тухай нийгмийн шүүмж, тайлбар, мэтгэлцээний хүрээнд анх гарчээ. Энэ нь эрх чөлөө бүр ямар нэг хариуцлага, үүргийг агуулж байдгийн адил хэвлэл мэдээлэл ч онцгой эрх эдэлж байдгийн хувьд нийгмийн өмнө хариуцлага хүлээж, өөрийн үүргээ гүйцэтгэж байж сая оршин тогтнох ёстой гэсэн онол ном юм

Либерал онол нь Европын Сэргэн мандалтын эрин үеийн ертөнцийг үзэх үзлийн үр юм. Тиймээс ч мөнхийн оршигч И.Ньютоны ертөнцийн тогтолцоонд үл өөрчлөгдөгч байгалийн хууль, оюун ухаант хүсэл зорилгот хүмүүний төрөлх эрхийн тухай Ж.Локкийн философи, сонгодог эдийн засгийн төрийн хязгаарлагдмал оролцоо, жам ёсны эрх чөлөө бүхий зах зээлийн өрсөлдөөний нөхцөлд хүн бүр хувийн эрх ашгаа даган амьдрах бололцоог олгосноор, өөрөө өөрийгөө зохицуулагч, цэцэглэн хөгжсөн аж ахуй үндэстний баялгийг бүтээх тухай сургаал, Жон Милтоны чөлөөт нээлттэй үзэл бодлын орчныг тэтгэх замаар

үнэнийг олж болох санаа зэрэг либерал онолын эх үндэс, суурь байв.

Харин ХХ зуун бол Эйнштейны харьцангуй онол, Ч.Дарвины хувьслын сургаал, Ж.Кейнсийн төрийн зохицуулалт бүхий эдийн засгийн номлолын зуун байлаа. Энэ тухай Ж.Йенсен бичихдээ “Чөлөөт хэвлэлийн уламжлалт философийн үзэл ойлголт эрчтэйгээр орчин үеийн сэтгэлгээний хувьсгалд нуран унаж байсан нь бүхнээс тодорхой байв. Ньютоны тогтвортой, туйлын үнэн байсан ертөнцийн хууль орчин үеийн физикийн харьцангуй, өөрчлөлт бүхий онолын сэтгэлгээнд зүгээр л эвдэрч орхив. Локкийн төрөлх эрхийн тухай номлол философийн төдийгүй, нийгмийн шинжлэх ухааны оргил санаа байхаа болив. Сонгодог эдийн засгийн чөлөөт үйлдвэрлэлийн онол ч орчин үеийн ихэнх эдийн засагчдын хувьд онцгой зүйл биш болов. Гэхдээ энэ бүхнээс илүү Ж.Милтоны “үнэнийг мэдэх” онол номлол итгэл үнэмшилтэй сонсогдохоо болилоо”⁴ гэжээ.

Тиймээс бие хүнийг дээдлэгч үзэл номлолын зарчимд тулгуурлан, хамт нийтийн зарим нэг “санааг” хүлээн авах нь юу юунаас илүү зөв болоод байв. Үүнийг ч нийгмийн өмнө хариуцлагатай сэтгүүлзүйн онол агуулж чадсанаараа тоталитар хандлага уруу хэлбийх аюулыг тойрч гарсан юм. Энэ нь хэт

төвлөрөл, төрийн хяналт зохицуулалт нь дарангуйлал уруу зайлшгүй хөтлөхийг мэдэрсэн улс төрийн бодлогын төдийгүй, хэвлэл мэдээллийнхэн зөвхөн ашиг орлого бус нийгмийн өмнө хүлээсэн үүрэг хариуцлагаа ухамсарласны үр дүн байлаа. Түүнчлэн эдийн засгийн хүрээнд ч үйлдвэрлэгчид, худалдаачид хувийн эрх ашиг, сонирхлоо дээдэлснээр нийгмийн баялгийг бүтээдэг тухай үзэл, итгэл үнэмшлээ залруулж, нийгмийн өмнө тодорхой хариуцлага хүлээх болсноо зөвшөөрсөн юм.

1947 онд гарсан Хэвлэлийн эрх чөлөөний асуудал эрхэлсэн комиссын илтгэлээр сая асуудал тодорхой болсон юм. Комисс орчин үеийн нийгмийн шаардаж буй мэдээллийн орчинд зайлшгүй баримтлах ёстой таван үндсэн эрэлтийг тодорхойлжээ. Үүнд нэгдүгээрт, Комиссын томъёолсноор "цаг үеийн үйл явдлын тухай үнэн бодит, бүрэн дүүрэн, нягтлан үзсэн тоймыг" мэдээлэх үүрэгтэй ажээ. Түүнчлэн энд баримт баримтаараа, үзэл бодол үзэл бодлоороо байж, уншигчдад баримт ба үзэл бодлын ялгааг тодотгон зааглан өгч байхыг онцолжээ. Тиймээс мэдээллийг бодитой, хувийн үзэл хандлагаас ангид, бүхий л тал, хүчин зүйлийг тэнцвэртэйгээр нэгтгэн боловсруулах үүрэг сэтгүүлчдэд, хариуцлага мэдээллийн хэрэгсэлд зайлшгүй зүйл болов.

Комисс ч асуудлыг бүр тодорхойгоор "Нийтлэгдэж буй баримт үнэн байх нь хангалттай биш. Одоо баримтын тухай үнэнийг мэдээлэх нь шаардлагатай болжээ" хэмээн томъёолжээ. Хоёрдугаарт, хэвлэл мэдээлэл нь "нийгмийн үзэл бодол ба байр суурийн солилцооны индэр" байх ёстой ажээ. Нэн ялангуяа томоохон мэдээллийн байгууллагад өөрсдийгөө нийгмийн шүүмжлэл, үзэл бодлын солилцооны талбар гэдгээ мартаж өсгүйг онцлон тэмдэглэжээ.

Мэдээллийн "аварга"-ууд олон нийтийн санаа бодолдоо тулгуурлан, нийтлэл нэвт-рүүлгийн баримт агуулгаа сонгох, өөрсдийн үзэл, үнэлэмжээр үйл явдал, асуудалд хандахаас татгалзах, эзэмшигч, эздийн байр суурийг бус, харин тал бүрийн эх сурвалж, хүчин зүйлийн хүрээнд тайлбар дүгнэлтээ тодорхойлох хэрэгтэй гэжээ. Учир нь либертари үзлийг эхэн үед төр засаг, эрх баригчид нийгмийн дуу хоолойн дайсан" байсан бол өдгөө томоохон мэдээллийн компаниуд хувь хүний үзэл бодлыг "дарангуйлагч" болж хувирах аюул бодитой болжээ.

Гуравдугаарт, хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь нийгмийн бүх бүлэг, давхарга, хүрээний "дүр зураг"-ийг тусгагч, илэрхийлэгч байх ёстой ажээ. Үүнд цагаачид үндэсний цөөнх хөгжлийн

бэрхшээлтэй иргэд зэрэг нийгмийн хүрээний тухай үнэн бодит, байр суурь, эрх ашгийг нь тодотгосон мэдээллийн "урсгал"-ын ач холбогдол онцгой болсныг, эсвэл тэдний дүр төрх, амьдрал ахуйг сөрөг, худал хуурмаг ойлголт, эсхүл "өрөвдөлтэй" мэтээр төсөөлдөг сэтгэхүйг өөрчлөх хэрэгтэйг дэлгэрүүлэн тайлбарлажээ.

Дөрөвдүгээрт, нийгмийн эрхэмлэл, үнэлэмж, үнэт зүйлийг илэрхийлэх, тодотгох үүрэг байна. Энэ бол хэвлэл мэдээллийнхний тэргүүн зэргийн нийгмийн өмнө хүлээсэн үүрэг гэжээ. Социал-хэвлэлийн редакцийн нүүр, телевизийн тоймын цаг, кино найруулагчийн шийдэл зэрэг нь нийгмийн үнэлэмжийг илэрхийлэгч, хүндэтгэгч төдийгүй, тийм уламжлалыг баталгаажуулагч үүргээр хэм хэмжээ нь тодорхойлогдох ажээ.

Тавдугаарт, нийгмийн мэдээлэл авах, мэдээлэлтэй байх эрхийг хангах ёстой гэжээ. Комиссын үзэж байснаар бол баримт мэдээллийн үнэлэмж, шалгуур нь цаг үеийн өргөн хүрээний, олон талт байдлаар тодорхойлогдох болжээ. Өөрөөр хэлбэл, хэвлэл мэдээлэл нь аль болох нийгмийн өргөн хүрээг хамарч буй

эсэхээрээ л "мэдээллийн эрх чөлөө" хэмээх ойлголтыг тодотгох болно гэсэн үг болжээ. Нийгмийн өмнө хэвлэл мэдээлэл хариуцлага хүлээнэ гэдэг ч ёс суртахууны үүрэг, мөрдлөгийг баримтлана гэсэн үг.

Либерал онолын үзэл бодлоо илэрхийлэх хүний төрөлх эрх нь ямар нэг үүрэг хариуцлагыг "агуулдаггүй" байв. Хүн чөлөөтэй үзэл бодлоо илэрхийлж, бусад нь ч чөлөөтэй сонсдог байсан гэсэн үг. Бас хүн, үзэл бодолтой байсан ч илэрхийлэхгүй байх, бусад нь сонсохгүй байх

«

Либерал онолын үзэл бодлоо илэрхийлэх хүний төрөлх эрх нь ямар нэг үүрэг хариуцлагыг "агуулдаггүй" байв. Хүн чөлөөтэй үзэл бодлоо илэрхийлж, бусад нь ч чөлөөтэй сонсдог байсан гэсэн үг. Бас хүн, үзэл бодолтой байсан ч илэрхийлэхгүй байх, бусад нь сонсохгүй байх эрхтэй байлаа.

»

эрхтэй байлаа. Тиймээс ч төрөлх эрх нь үнэнийг олох, "нийгэмд ашигтай" байх гэсэн зарчимд үндэслэгдсэн шигээ хүмүүст ойлгогдож, бодит байдалд ч тийнхүү оршсоор иржээ.

Харин нийгмийн хариуцлага бүхий хэвлэлийн онолын хувьд үзэл бодлоо илэрхийлэх нь ёс суртахууных нь үүрэг болж, итгэл үнэмшил, хүн чанарынх нь баримтлал, мөрдлөгийн зайлшгүй болон тодорхойлогддог. Үүнийг ч Хокинг "эрх чөлөө нь ёс суртахууны үүрэгтэй. Харин ёс суртахууны үүрэг нь өөрийн хувийн эрх ашгаасаа татгалздаггүй шиг, тийм

чухал эрхэм үнэлэмж"⁵ хэмээн тэмдэглэжээ.

Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө нь ч хувь хүний төдийгүй, нийгмийн эрх ашиг хэмээн үздэг. Комиссын илтгэлд ч "Хэрвээ хүнд чухал үзэл баримт байгаа бол түүнийгээ илэрхийлэх үүрэгтэй. Энэ бол түүний нийгмийн сайн сайхан болоод өөрийнхөө хүн чанарын өмнө хүлээж буй үүрэг болно. Тиймээс үзэл бодлоо илэрхийлэх нь зайлшгүй үүрэг бөгөөд энэ нь нийгэм, түүнээс ч илүү зүйл тухайлбал үнэний өмнө хүлээх хариуцлага"⁶ хэмээн онцолжээ.

Нөгөөтэйгүүр үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө нь хүний туйлын дээд эрх зориг тэр дундаа бусдын эрх ашгаас өөрийнхийг илүүд үзэх, нийгмийн үнэлэмж, дэг журмыг үл ойшоох "дарх" хэмээн ойлгож болохгүй гэдэг. Бурхнаас хүнд заяасан төрөлх хишиг болох эрх чөлөө хэмээх ойлгох нь төр засгийн дарангуйллыг яллах түүхэн үүргээ гүйцэтгээд нэгэнт өнгөрчээ. Тиймээс өнөөдөр эрх чөлөөний асуудлыг өөрөөр үзэх, эргэн харах нь зайлшгүй зүйл болоод байгаа ажгуу.

Зөвлөлтийн коммунист хэвлэлийн онол нь К.Марксын үзэл санаанаас эх авсан сэтгүүлзүйн номлол юм. Тиймээс К.Марксын үзэл санааг ойлгохоос асуудлыг эхлэх ёстой. Энэ тухай В.Вышинский "Марксаас өмнөх нийгэм судлал болон

түүхэн бичлэг нь ердөө хэсэг бусаг "нүцгэн" баримтын цуглуулга, эсхүл аль нэг түүхэн үйл явдлын тойм төдий зүйл байсан юм. Харин марксизм нийгэм-эдийн засгийн хэлбэршлийн хөгжил, зөрчлийн онолын үүднээс үйл явдал, үзэгдлийг өргөн хүрээнд, бүхнийг багтаан үзэх замыг нээсэн юм. Тэрээр нийгмийн бүхий л зөрчилт үзэгдэл, асуудлыг нэгтгэн авч үзэхдээ янз бүрийн ангийн амьдралын хэв маяг, эдийн засгийн харьцааг үндэслэн онолоо бичсэн. Ийнхүү үндсэн санаагаа бататган тайлбарласан дурын сонголтоор нийгэм түүхийн хөгжлийн тайлбар дүгнэлтээ боловсруулсан юм. Тэгээд ч материаллаг үйлдвэрлэлийн үйлдвэрлэх хүчинтэй холбоотой бүхий л үзэл бодол, шинжилгээ болоод янз бүрийн хандлага үзэгдлийг бүгдийг түүсэн"⁷ гэжээ. Марксын үзэл санааны өөр нэгэн онцлог зүйл нь нэгдмэл байдал хэмээх ойлголтоор нийгмийг ч тэр, түүхийг ч тайлбарлаж байсанд юм. Энэ ч утгаараа ажилчин ангийн нэгдмэл байдал, ангийн тууштай тэмцэл, эсрэг тэсрэгийн нэгдэл гэх мэтийн ойлголтыг өргөн хэрэглэж байв. Тэр бүү хэл аливаа үзэгдэл үйл явдлыг урьдчилан дүгнэх нарийн тодорхой заалт, хязгаар бүхий үзэл суртлын "цонх", хүн төрөлхтний түүхийн хөгжил зөрчлийг цөөн тооны эдийн засгийн баримт, үнэлэмжээр үнэлэх ер бусын

итгэл үнэмшил байсан юм. Өөрөөр хэлбэл марксизм анхнаасаа л авторитар, үл өөрчлөгдөгч ягшмал номлол байсан гэсэн үг.

Өөрчлөгдөгч хийгээд үл өөрчлөгдөгч хүний ертөнцийн тухай асуудал эртнээс нааш философийн маргаан, мэтгэлцээн, үзэл санааны төв байжээ. Дорно дахины хийгээд Платоны сургуультай болон христын уламжлалт философийн урсгалынхан үл өөрчлөгдөгч ертөнцийн тухай эргэцүүлсээр ирэв. Харин Марксын амьдарч байсан цаг үе бол биологийн хувьслын хууль "нээгдэж", машинт, аж үйлдвэржилтийн хувьсгал шууд нийгмийн амьдралд суурь өөрчлөлтийг дагуулснаараа онцгой байлаа. К.Маркс энэ бүх өөрчлөлтийн нууц шалтгааныг идэвхитэй эрэлхийлж, хариултаа ч олсон юм. Тэр нь Гегелийн диалектик хэмээх ойлголт байсан юм. Диалектик үзлээр бол эсрэг тэсрэг хоёр хүчин зүйлийн үгүйсгэлээр нэгдэл үүсдэг ба тэр нь бүх юмс үзэгдлийн зайлшгүй чанар ажээ. Үүнийг К.Маркс ангийн тэмцлийн сургаалаа тайлбарлахад ашиглан, ажилчин анги хөрөнгөтнийг ялах, шинэ ангигүй нийгэм байгуулах тухай онолоо боловсруулжээ. Түүний материалист учир шалтгааны онол баримтлал нь Гегелийнхээс өөр ялгаатай юм. Гегелийнхээр оюун санаа нь бие даасан ертөнц бөгөөд бодит

байдал нь ердөө гадаад "санаа"-ны тусгал төдий зүйл ажээ. Харин К.Маркс бодит материаллаг ахуй нь, яаж амьдарч, амьдралаа хэрхэн авч яваа нь л хүний бодол санаа, төсөөллийг тодорхойлдог гэжээ. Өөрөөр хэлбэл эдийн засаг, үйлдвэрлэх хүчний тогтолцоо болоод үйлдвэрлэлийн харилцаа нь нийгмийн дүр төрх, амьдралыг тодорхойлогч хүний ахуй байдлын үндсэн хүчин зүйл гэжээ.

Ийнхүү К.Маркс Баруун Европын эдийн засгийг судалж, нийгмийн өөрчлөлт зайлшгүй хэмээн зарлажээ. Тэрээр үйлдвэрлэх хүч нь үйлдвэрлэлийн харилцаанаасаа илүү хурдан өөрчлөгдөж, үүгээрээ ч нийгмийг тогтворжуулдаг гэж үзжээ. Харин капитализмд үргэлж эдийн засгийн хямрал, баян хоосны зөрчил байдаг учир дарлагдагч ангийн тоо хүрээ өргөжин тэлэх нь гарцаагүйг, капитализмын дараагийн үе шат империализмд дайн самуунаар үргэлжлэхийг тэмдэглэжээ. Тиймээс эцсийн эцэст ажилчин анги тэвчээр алдан, босох болно хэмээн "зөгнөжээ". Улмаар хүн төрөлхтөн нэг анги нөгөөгөө дарлах хэрэгсэл болсон төрийг устгаж, ангигүй нийгэм байгуулах болно гэж "зөгнөлөө төгсгөжээ". Эрх чөлөө, бие хүний бие даасан байдлын талаар коммунист онол либертари үзлээс эрс өөр, эсрэг байр суурьтай

байсан юм. В.И.Ленин "...нийгэмд амьдарч байж түүнээс чөлөөтэй байна гэдэг боломжгүй зүйл... Үнэн бол зөвхөн намд л байдаг ... Мөнгөн дээр үндэслэгдсэн нийгэм мөнгөнөөс хараат бус байж чадахгүй"⁸ зэргээр бичиж байжээ. Тэрээр алдарт "Намын байгууллага ба номч утга зохиол" өгүүлэлдээ "...хөрөнгөтний бодгаль үзэлтэй ноёдоо абсолют (төгс — зох.) эрх чөлөөний тухай та нарын хэлдэг үг тэр аяараа хуурамч үг болохыг та нарт бид хэлэх ёстой. Мөнгөний ноёрхол дээр үндэслэсэн нийгэмд, хөдөлмөрчин олон түмэн гуйланчилж, хэдхэн баячууд бусдыг сорон мөлжиж байгаа нийгэмд жинхэнэ бодитой "эрх чөлөө" байж болохгүй"⁹ гэж бичжээ. Зөвлөлтийн сэтгүүлзүйн онолын хувьд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх асуудлыг хэрэгцээгүй, намын эрх ашигт үл нийцсэн зүйл гэж үзэж байв. Үзэл бодлын эрх зөвхөн намын дотоод зохион байгуулалт, төрийн бодлогын хүрээнд л байх ёстой ажээ. В.И.Ленин "Хүн бүхэн юу дуртайгаа ямар ч хязгаарлалтгүй бичих хэлэх эрх чөлөөтэй юм. Гэвч чөлөөтэй эвлэл бүхэн (түүний дотор нам) нь намын эсрэг үзлүүдийг номлохын тулд намын нэрийг ашигладаг тийм гишүүдийг хөөхдөө бас чөлөөтэй байна. Үг хэлэх хэвлэх бүрэн эрх чөлөөтэй байх ёстой. Гэтэл бас эвлэлдэх бүрэн эрх чөлөөтэй байх ёстой шүү дээ... Нам бол

сайн дурын эвлэл мөн бөгөөд тэр нь хэрэв намын эсрэг үзлүүдийг номлодог гишүүдээс биеэ цэвэрлэхгүй юм бол эхлээд үзэл санааны, дараа нь материалын талаар зайлшгүй задран унах болно"¹⁰ гэж бичсэн нь коммунист онолын эрх чөлөөний тухай хамгийн тодорхой дүгнэлт билээ.

Коммунист болон либертари хэвлэлийн онолын ялгаа нь гүн ухааны эх сурвалж, үндэслэгчдийнхээ үзэл бодолд хамгийн ил тод бйдаг. К.Маркс хүнийг хөгжүүлэхийн тулд эхлээд нийгмээ сайжруулахыг хүсч, хүнийг ердөө нийгмийг сайжруулагч хүчин зүйл, хөдөлгүүр хэмээн ойлгож байжээ. Харин либертари үзлийн үндэслэгч Ж.Милл хүнээ хөгжүүлсний дараа нийгэм аяандаа сайжирна гэж томъёолжээ. Асуудлын ялгаа энд, эндээс л эхэлж байгаа юм. Бас төгсөж байна. Зөрчил бол нийгмийн эрүүл үзэгдэл гэж либертарчууд үзэж байхад коммунистууд нуран унаж буйгийн илрэл хэмээн тодорхойлж байжээ. Хувь хүний үзэл бодол бол хэрэгцээгүй, эрх чөлөө гэгч хоосон дэмий яриа болохыг В.И.Ленин тэмдэглэж байсан бол Т.Жефферсон "төр засаггүй ч хэвлэл мэдээлэлтэй байсан" нь илүү зөв сонголт гэж хэлж байжээ.

Эцэст нь тэмдэглэхэд авторитар сэтгүүлзүйн онол номлолоор хүн гэгч

өчүүхэн нэгэн бөгөөд түүний үзэл бодол хүсэл эрмэлзлэл гээд байх шалтай зүйл үгүй ямагт бусдын дэмжлэг хамт нийтийн оролцоотойгоор л сая бодит зүйл болох ба харин либертар тайлбараар хүн сайн муу сайхан муухай бүхнийг ялган ойлгогч, үнэнийг нээгч, өөрөө өөрийгөө мэдэгч нэгэн болой. Гэтэл нөгөө талд коммунист сэтгүүлзүй хүний үзэл бодол, зан чанар тэр бүү хэл амьдрал ахуйг өөрчлөгч "зохион бүтээж" болохыг онцолж байхад нийгмийн хариуцлагатай сэтгүүлзүй хүний нэр төр, бүхнийг мэдэж байх эрхийг тунхагладаг ажгуу.

Ишлэл

¹ Б о а з Д. 2005. Либертарианизм. УБ., 57 дахь тал.

² С и б е р т Ф., Ш р а м м У., П и т е р с о н Т. 1998. Четыре теории прессы. М., с. 72.

³ M i l l J. S. 1947. On Liberty. N.-Y., p. 38.

⁴ J e n s e n J. 1950. Toward a Solution of the Problem of Freedom of the Press. N.-Y., p. 401.

⁵ С и б е р т Ф., Ш р а м м У., П и т е р с о н Т. Указ. соч., с. 145.

⁶ Мөн зох., 147 дахь тал.

⁷ V y s h i n s k y A. 1948. The Law of the Soviet State. N.-Y., p. 82.

⁸ I n k e l e s A. 1950. Public Opinion in Soviet Russia. C., p. 136.

⁹ 1972. В.И.Ленин хэвлэлийн тухай. (Ред. Д.Норовсамбуу). УБ., 15 дахь тал.

¹⁰ Мөн эмхэтгэл, 18 дахь тал.

Резюме

В настоящей статье автор поставил целью выявление места и значения личности в четырёх основных теориях прессы — авторитарной, либертарианской, социальной ответственности и коммунистической советской, что имеет немаловажное значение, так как человек занимает центральное место в информационной коммуникации. Каждая из этих принципиально разных теорий уделяла различное место индивидууму, исходя из собственной идеологии и ценностей.